

“Дархан нэхий” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны дугаар сарын-ны өдрийн
..... тоот тогтоолын хавсралт №.....



**“ДАРХАН НЭХИЙ” (ХК) ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Дархан нэхий” (ХК) Хувьцаат компаниас /цаашид компани гэх/ эрх бүхий байгууллагуудад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү мэдээллийн үйл ажиллагааны журам нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, заавар болон компанийн дотоод журамд нийцсэн байна.
- 1.3 Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
 - 1.3.1 “Мэдээллийг нээлттэй болгох” гэж үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг;
 - 1.3.2 “Тухай бүр мэдээлэх” гэж үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг;
 - 1.3.3 “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д болон “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай ” журамд заасан этгээдийг;
 - 1.3.4 “Хугацаат тайлан” гэж үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг.

Хоёр. Нийтэд мэдээллийг тогтмол хүргэх

- 2.1 Хугацаат тайланг нийтэд мэдээлэх
 - 2.1.1 “Дархан нэхий” ХК-ийн хугацаат тайланд хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаас гаргагчын мэдээллийн ил тод байдлын

журам” /цаашид “Мэдээллийн ил тод байдлын журам” гэх/- д заасан хэлбэрийн дагуу нийтэд мэдээллэнэ.

- 2.1.2 Хугацаат тайлангийн мэдээллийг бүрдүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг компанийн мэдээллийн ажилтан хариуцан ажиллах бөгөөд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаандаа олон нийтэд хүргэж ажиллахад компанийн удирдлага дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.1.3 Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор Мэдээллийн ил тод байдлын журмын 2.4-т заасан агуулгаар өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ.
- 2.1.4 Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Мэдээллийн ил тод байдлын журмын 2.3-т заасан агуулгаар өөрийн компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 2.1.5 Хэрэв компанийн хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нийтэд мэдээлэхээс өмнө компанийн ашиг, алдагдалын хэмжээ нийтэд тархаж энэ нь компанийн гаргасан үнэт цаасны үнэ ханшийг 15 хувь өөрчлөгдөхөд хүргэсэн бол компани тухайн тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн талаар нэн даруй нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.
- 2.1.6 Компанийн үйл ажиллагааны тайланд компанийн засаглалийн тайлан, компанийн засаглалын кодексийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар заавал тусгасан байна.

2.2 Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг Мэдээллийн ил тод байдлын журмын 3.2-т заасан агуулгаар аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал өөрчлөлт болсоноос хойш ажлын нэг өдөрт багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

2.3. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг өөрийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах ажлыг Компанийн ТУЗ-н нарийн бичгийн дарга хариуцна. Уг мэдээллийн үнэн байдлыг компани хариуцна.

Гүрээ. Компанийн талаар мэдээлэл авах

3.1 Компани нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулна.

- 3.2 Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчид олгох үүрэг хүлээнэ.
- 3.3 Хувьцаа эзэмшигчээс мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан энэхүү журамд хориглоогүй мэдээллийг цахим шуудангийн хаягаар хүргүүлж болно.
- 3.4 Компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.
- 3.5 Компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага энэ журмын 3.4-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавьсан этгээд хариуцна.

Дөрөв. Нийтэд мэдээлсэн мэдээллийн архивыг бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа

- 4.1 Компани нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл 5 жилийн хугацаанд байршина.
- 4.2 Олон нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа тэдгээрийг архивт шилжүүлнэ.
- 4.3 Энэхүү журмын 4.2-т заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг энэхүү журмын 2.3-т заасан ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Тав. Мэдээллийг нээлттэй болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйл


- 5.1 Дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцлийг бүрдүүлэхийг хориглоно.
- 5.2 Дотоод мэдээлэл эзэмшигчид дараах зүйлийг хориглоно:
- 5.2.1 уг мэдээллийн улмаас ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцох;

- 5.2.2 уг мэдээллийг дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш, арилжааны хэмжээ нь хэлбэлзэх үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцохыг бусдад санал болгох, ятгах;
- 5.2.3 албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах.
- 5.3 Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон бол энэ журмын 5.2-т заасныг зөрчсөнд тооцно.
- 5.4 Компани нь дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийхийг хориглох бөгөөд үүнийг зөрчвөл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж арга хэмжээ тооцно.
- 5.5 Компани нь дотоод мэдээллийг хөрөнгийн бирж, Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх ба дотоод мэдээллийг нийтэд мэдээлэхдээ Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэнэ.
- 5.6 Дотоод мэдээллийг дор дурдсан хэлбэрээр нийтэд мэдээлнэ:
- 5.6.1 үнэт цаас гаргагч, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон Хорооны цахим хуудсаар;
- 5.6.2 Хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх;
- 5.6.3 тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.
- 5.7 Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

Зургаа. Бусад

- 6.1 Мэдээллийг тайлагнах, нээлттэй болгоход компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль журмын дагуу оролцоно.
- 6.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийг дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөн эрх бүхий байгууллага, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.
- 6.3 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны тухай хууль, компанийн дотоод журманд заасын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.4 Энэхүү журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Мэдээллийн ил тод байдлын журам бусад эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.
- 6.5 Компаниас гаргаж буй аливаа мэдээлэл нь энэхүү журмын 6.4-т заасан эрх зүйн баримт бичгүүдэд нийцсэн байна.
- 6.6 Энэхүү журмыг зөрчсөнөөс холбогдон үүсэх хохиролыг хариуцлага ногдуулсан эсэхээс үл хамааран буруутай ажилтан, албан тушаалтан нөхөн төлж барагдуулна.

Ганшигчид:



2012